



**ЧИНГЭЛТЭЙ ДУУРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 06 чадв.

Дугаар 30

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17, 18 дугаар зүйлийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ амар тайван амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, иргэдэд хууль тогтоомж сурталчлах, мэдээлэл хүргэж зорилгоор хороодод ажиллах олон нийтийн байцаагчийн ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар, олон нийтийн байцаагчийг сонгон шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар, хувцасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Олон нийтийн байцаагчийг сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, 2013 оны 04 дүгээр сард багтсан томилон ажиллуулахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д зөвлөсүгэй.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Менхбат/, Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга /Г.Эрхэмбаяр/, 2 дугаар хэлтсийн дарга /Г.Эрдэнэбаатар/, хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Олон нийтийн байцаагчийн ажлын үр дүнг жил улирлаар тооцон дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж байхыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 14 дүгээр тогтооолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

2150010053

Чингэлтэй дүүргийн Иргэдийн
Төлөвлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2013 оны 03 дугаар сарын 16-рдийн 20
дугаар тогтооплын нэгдүгээр хавсралт

Хороодод ажиллах олон нийтийн
байцаагчийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмыар хороодод ажиллах нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч /цаашид олон нийтийн байцаагч гах-/ийн ажлын зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх, үүргийг тодорхойлж, бусад байгууллага, албан тушаалтантай харьцах, хамтарч ажиллах хэлбэрийг тогтооно.

1.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу дүүргийн Иргэдийн Төлөвлөгчдийн Хурал харьва нутаг дэвсгэр /хороол-/нд ажиллах олон нийтийн байцаагчийн тоог тогтоож, дүүргийн Засаг дарга тадгээрийг томилон, гэрээ байгуулж ажиллуулна.

1.3. Олон нийтийн байцаагч нь үйл ажиллагаандаа "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хууль, "Захиргааны хариуцлагын тухай" хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг удирдлалтаа болгон ажиллана.

1.4. Олон нийтийн байцаагч нь хорооны иргэдийн Нийтийн Хурлын даргын удирдлалын дор үйл ажиллагаагаа явуулж, хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг даргад тайлагнана.

1.5. Олон нийтийн байцаагч жил, улирлаа ажлаа төлөвлөн гаргаж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эхицуулах салбар зөвлөлийн даргаар баттуулж ажиллана.

Хоёр. Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааны зорилго,
үндсэн чиг үүрэг

2.1. Тухайн хорооны нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын орцлог хангах, энэ чиглэлээр тэр, захирагаа, хууль хяналтын байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргийн хурзэнд хийж хэрэгжүүлж байгаа ажилд дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах замаар иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нэхцлийг бурдүүлэхэд олон нийтийн байцаагчийн ажлын зорилго оршино.

2.2. Олон нийтийн байцаагч нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана:

2.2.1. Хууль сурталчиллах, нийтээр дагаж мөрдөхөөр эрх бүхий байгууллагуудаас гаргасан дүрэм, журмыг тайлбарлан таниулах, иргэдийн дунд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;

2.2.2. Хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, үйлчилгээний газруудын байршил, цагийн хуваарь, захирап, эрхлэгч /эзэн/-ийн нэр хаяг, утасны дугаар эзэг мэдээлэл бүхий төрөлжисэн бүртгэл судалгаа хөтөх, дээрх газруудын үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгах талаар шаардлагыг мэдрэгдэл хургуулж, тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд засхиргаа, хууль хяналтын байгууллагад мэдэгдэх;

2.2.3. Харьяа нутаг дэвсгэртээ олон нийт, иргэдийн оролцоотой зргүүлийг зохион байгуулж, удирдлагавар хангаж ажиллах, гудамж, талбайд гарсан хэв журмын зөрчлийг арилгах, таслан зогсох арга хэмжээ авах;

2.2.4. Хорооны хэмжээнд гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй, гэр булийн хүчирхийлэлд өртөх магадлалтай, гэмт хэргийн хохирогч болж болзошгүй иргэдийн бүртгэл судалгаа хөтлөх, түүнд налөөллийн үнэлэлт дүгнэлт хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах;

2.2.5. Хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, нехцийн судалж, дүгнэлт хийж, цаг хугацаа, орон зай, давтамж, оролцоч, хохирогчийн талаар дэлгэрэнгүй бүртгэл, судалгаа хөтлөх, энэ талаарх танилцуулгын дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлж байх;

2.2.6. Нийгмийн хэв журам зөрчиж, гэмт хэрэг үйлдэж болзошгүй нехциел байдал үүссэн үед цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

2.2.7. Нийгмийн дэг журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн сэргээхүүлэг, анхааруулгын гудамж, талбай, олон нийтийн газруудад байршууллах, гудамж бүрйин үзүүрийн хашаанаа буланд гэмт хэрэг, нийгмийн дэг журмын зөрчлийн талаарх мэдээллийг нэн яаралттай хүргэх утасны дугаар бухий самбар байрлуулах;

2.2.8. Нийгмийн эзэмшилийн гудамж, талбайн ариун цэврийн сахиулах, хог, цас месний цэвэрлэгээнд иргэдийн оролцоотой хяналт тавьж, энэ хүрээнд нийслэл, дүүргээс тогтоосон дэг журмын сахиулах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шаардлага тавих, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

2.2.9. Замын хөдөлгөөний хууль тогтоомжийг сурталчилах, хорооныхоо хэмжээнд осол хэрэг гарч болзошгүй газруудын судалгааг гаргах, холбогдох байгууллагад мэдээлэх;

Гурав. Олон нийтийн байцаагчийн эрх

3.1. Олон нийтийн байцаагч нь дараах эрх эзлэн:

3.1.1. Хорооныхоо нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журувтай танилцах, батлагдсан удирдамжийн дагуу хяналт, шалгант хийх;

3.1.2. Хууль тогтоомж, нийгминд дэг журам зөрчсөн иргэний бичиг баримтыг шалгах;

3.1.3. Нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хууль, тогтоомж зөрчигчдэд шаардлага тавих, мэдэгдэл хүргүүлах, зөрчил дутагдлыг арилгасан тухай байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагаас тайлан, танилцуулга гаргуулж авах;

3.1.4. Нийгмийн дэг журам, хууль тогтоомжийг удаа дараа зөрчиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад арга хэмжээ авахуулах, шийтгэл ногдуулах саналыг захиргава, хууль, мэргэжлийн хяналтын байгууллагуудад, албан ёсоор хүргүүлэх;

3.1.5. Хууль тогтоомжийн хүрээнд торгууль ногдуупак;

Дөрөв. Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

4.1. Олон нийтийн байцаагчийн дараах үйлдэл, үйл ажиллагааг хориглоно:

4.1.1. Давхар ажил үүрэг гүйцэтгэх;

4.1.2. Хүн саатуулах, тэзвэрийн хэрэгслийг зогсох, иргэний биед болон тэзвэрийн хэрэгсэлд үзлэг хийх, бичиг баримтыг хурааж авах;

7.2. Хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санал дүгнэлтийг харгалзан дүүргийн ГХУСА33-өөс олон нийтийн байцаагчдад сар бүр цалин олгоно.

**Найм. Олон нийтийн байцаагчийг ажлаас чөлөөлөх,
хариуцлага хүлээнгэх**

8.1. Олон нийтийн байцаагч нь ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, зерчил дутагдал гаргасан тохиолдолд түүний ажлаас чөлөөлнэ.

8.2. Олон нийтийн байцаагч энэ журмын 8.1-д зассан үндэслэлээр ажлаас чөлөөлгэсэн бол түүнд олгосон ажлын хувцасны үний нэхэн төлвүүлнэ.

8.3. Олон нийтийн байцаагч нь өөрийн санаачлагазар ажлаас чөлөөлгэдэх тохиолдолд дүүргийн Засаг дарын Тамын газартай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу ажил хүлээнцэх акт үйлдэж, дурэмт хувцас болон холбогдох төлбөр тооцог барагдуулна.

8.4. Олон нийтийн байцаагч нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалт болон энэхүү журмыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Чингэлтэй дуургийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2013 оны 03 дугаар сарын 06 өдрийн 20
дугаар тогтолцоон хөөрдогаар хавсралт

Хороодод ажиллах олон нийтийн байцаагчийг
сонгон шалгаруулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дүүргийн хороодод ажиллах нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчар /цавшид олон нийтийн байцаагч гах/ нь Монгол Улсын иргэн, дээд боловсролтой, хуульч, эрх зүйч, багш, сурган хумуухуулэгч, нийгмийн ажилтны мэргжилтэй, сургалт сурталчилгааны ажил хийх, баримт бичиг боловсруулах, удирдамж зохион байгуулах чадвартай, 50 хүртэлх насны, Чингэлтэй дүүрэгт байнга оршин суудаг иргэний наэлттэй шалгаруулалтаар сонгон авч томилон ажиллуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Дээрх шаардлагыг хангасан, ажлын байрны чиг үүргийг мэргжлийн түвшинд хэрэгжүүлэх чадвартай иргэний сонгон шалгаруулна.

1.3. Олон нийтийн байцаагчийг сонгон шалгаруулахад хуулиа дээձлж, шударга, ил тод байх зарчмыг удирдлага болгоно.

1.4. Сонгон шалгаруулалттай холбогдож гарах зардлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан саргийлэх арга хэмжээний зардлаас гаргана.

Хоёр. Сонгон шалгаруулалтын зар мэдээ

2.1. Хорооны олон нийтийн байцаагчийн ажлын байрны сул орон тооны зар мэдээг сонгон шалгаруулалт явуулахаас 14-еес доошгүй хоногийн ёмне хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэнэ.

2.2. Сонгон шалгаруулалтын зар мэдээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын цахим хуудаст байршиулна.

2.3. Зар мэдээнд ажлын байранд тавигдах шаардлага, бурддүүлэх материал, материалын хулзэн авах хаяг, хугацаа, сонгон шалгаруулалт явуулах байр, хугацаа зэргийг заана.

Гурав. Сонгон шалгаруулах комисс, түүний чиг үүрэг

3.1. Олон нийтийн байцаагчийг сонгон шалгаруулах комисс /цавшид комисс гэх/-ийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр дарга, нарийн бичийн дарга, 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйзэр байгуулна. Комиссын бүрэлдэхүүнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэлтсийн болон мэргжлийн байгууллагуудын холбогдох албан тушаалтуудыг оруулна.

3.2. Олон нийтийн байцаагчийн ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд сонгон шалгаруулалтанд орсон иргэдээс неөөцд бүртгэж авсан онооны дарааллын дагуу уг орон тоог нөхнэ.

3.3. Сонгон шалгаруулах ажлын бэлтгэл, зохион байгуулалт, дун гаргах эзэр бүхий үйл ажиллагааг комиссын хуралдаанаар хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэн.

3.4. Комисс дараах үүргийг хэрэгжүүлна:

- 3.4.1. Сонгон шалгаруулалтын зарыг нийтэд хургах;
- 3.4.2. Олон нийтийн байцаагчаар ажиллах хүснэгттэй иргэдийн материал /өргөдөл, анкет буюу териин албан хаагчийн 1-р маягт, боловсролын дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар, үнэмлэх, Монгол Улсын иргэний үнэмлэх, ажил эрхэлдэг бол ажил байдлын тодорхойлолт, оршин сутгаа хорооны Засаг даргын тодорхойлолт, 4хб хэмжээний зураг 2 хувь-/ийг хулээн авч буяцах;
- 3.4.3. Бүртгүүлсэн иргэдийн ял шийтгэлтэй, эсэх талаарх тодорхойлолтыг цагдаагийн байгууллагаас, боловсролын дипломын үнэн зөв, эсэх лавлагаяг мэргэжлийн хянантын газраас ногдсан журмаар авах;
- 3.4.4. Сонгон шалгаруулалтад, орох иргэдээс авах ерөнхий мэдлэгийн түвшин тогтоо шалгалтын тест, ярилцлагын сэдэв, чиглэлийг боловсруулах;
- 3.4.5. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;
- 3.4.6. Сонгон шалгаруулалтын дүнг гаргаж, тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтыг дүүргийн Иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, Засаг дарга хургуулзах;
- 3.4.7. Сонгон шалгаруулалтын тайланг бичих, дүнг олон нийтэд мэдээлэх;

Дөрөв. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, дүнг гаргах

- 4.1. Сонгон шалгаруулалтын зар мэдээнд заасан өдөр, цаг, газарт ерөнхий мэдлэгийн түвшин тогтоо шалгалт авч, дүгнэнз.
- 4.2. Тестийн шалгалт нь териин алба, хууль эрх зүй, нийгмийн шинокслэх ухааны агуулгатай, 50 асуултаас бурдэнз.
- 4.3. Тестийн шалгалтын босго оноог зарлагдсан ажлын байрны тоо, бүртгүүлсэн иргэдийн тоо зэрэгээ хамаарч комисс тогтоож, зарлана.
- 4.4. Ерөнхий мэдлэгийн түвшин тогтоо шалгалтад тэнцсэн иргэдийг ярилцлагад оролцуулна. Ярилцлагын зорилго нь шалгаруулалтад орж байгаа иргэний ажлын туршилага, олон нийтийн байцаагчийн ажлын онцлог, чиг үүргийн талаарх төсөөлөл, ажил үүрэг гүйцэтгэх чадвар, боломж зэргийг тодорхойлоход оршино.
- 4.5. Энэ журмын 1.1-д заасан болзول, шаардлагыг хангаагүй, мен журмын 3.4.2-д заасан материалыг дутуу бүрдүүлсэн иргэнийг тестийн шалгалт, ярилцлагад оролцуулахгүй.
- 4.6. Комиссын хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг 2 хувь үйлдэж, дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
- 4.7. Комиссын шийдвэрийг үндэслэн дүүргийн Засаг дарга олон нийтийн байцаагчийг томилж, гэрээ байгуулан ажиллана.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн
Талеелгэгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2013 оны 03 дугаар сарын **16** өдрийн **20**
дугаар тогтоослын гуравдугаар хавсралт

**Хороодод ажиллах олон нийтийн байцаагчийн хувцасны
загвар, түүний тодорхойлолт**

1. Хороодод ажиллах олон нийтийн байцаагчийн ажил үүргийн онцлогыг харгалзан ажлын тусгай хувцсаар хангана.
2. Ажлын хувцсыг зөвхөн ажлын байранд болон албан үүрэг гүйцэтгэх үед емсөж хэрэглэнэ.
3. Хувцас нь өвөл, зуны гэсэн төрөлтэй байна.
4. Зуны хувцсанд малгай, хүрэм, брюкэн өмд /юбка/, ботинк, өвлийн хувцсанд малгай, дотортой хүрэм, дуплан өмд, хагас турийтэй өвлийн гутал байна.
5. Зуны малгай нь хар саарал өнгийн саравчтай малгай байна.
6. Өвлийн малгай нь хар саарал өнгийн, хиймэл үстэй, дотогшоо чихтэй байна.
7. Малгайд олон нийтийн байцаагчийн тэмдэг, эмблем хадна.
8. Зуны хүрэм нь боссоо захтай, бартаагүй, задгай энгэртэй, ердийн товчтой, хар саарал өнгетэй, энгэрийн болон ташааны хармаатай байна. Зүүн гарын ханцуйд бамбай хэлбэртэй, улаан хүрээтэй, цэнхэр өнгийн дэвсгэр дээр голлуулан "ОНБ" гэсэн товчилсон угийг энгэрийн хармааны дээд талд "Олон нийтийн байцаагч" гэсэн угийг комьютерээр хатгаж оёсон байна.
9. Өвлийн хүрэм нь үстэй захтай, дотортой, хар саарал өнгетэй, ердийн товчтой, энгэрийн болон ташааны хармаатай байна. Зүүн гарын ханцуйд бамбай хэлбартай, улаан хүрээтэй, цэнхэр өнгийн дэвсгэр дээр голлуулан "ОНБ" гэсэн товчилсон угийг, энгэрийн хармааны дээд талд "Олон нийтийн байцаагч" гэсэн угийг комьютерээр хатгаж оёсон байна.
10. Өвөл, зуны хүрэмний арын хэсгийг голлуулан "Олон нийтийн байцаагч" гэсэн угийг комьютерээр хатгаж оёсон байна.
11. Өвөл, зуны өмд /юбка/, хүрэм нь ижил өнгө, материалтай байна.
12. Ботинк, хагас турийтэй өвлийн гутал нь хар өнгетэй байна.